



МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ  
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 01 сарын 22 өдөр

Дугаар А/12

Улаанбаатар хот


Хүн амын амьжиргааны 2019 оны доод  
түвшинг тогтоох тухай

Монгол Улсын Статистикийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дүгээр заалт, Хүн амын амьжиргааны доод түвшинг тодорхойлох тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1, 5 дахь хэсэг, Үндэсний статистикийн хорооны даргын зөвлөлийн 2019 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Хүн амын амьжиргааны доод түвшин"-ий 2019 онд мөрдөх хэмжээг хавсралтаар баталж, 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдүүлсүгэй.

2. Шинэчлэн баталсан "Хүн амын амьжиргааны доод түвшин"-г холбогдох байгууллагад албан ёсоор хүргүүлж, нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Ч.Цэвэгдорж/-т даалгасугай.


ДАРГА



А.АРИУНЗАЯА

000028

Үндэсний статистикийн хорооны даргын  
2019 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн  
А/12. дугаар тушаалын хавсралт



### ХҮН АМЫН АМЬЖИРГААНЫ ДООД ТҮВШИН, БҮС НУТГААР

Бүс нутаг	Хамрагдах аймаг	Амьжиргааны доод түвшин, төг
1. Баруун бүс	1. Баян-Өлгий 2. Говь-Алтай 3. Завхан 4. Увс 5. Ховд	190700
2. Хангайн бүс	1. Архангай 2. Баянхонгор 3. Булган 4. Өвөрхангай 5. Хөвсгөл 6. Орхон	194300
3. Төвийн бүс	1. Говьсүмбэр 2. Дорноговь 3. Дундговь 4. Өмнөговь 5. Сэлэнгэ 6. Төв 7. Дархан-Уул	187100
4. Зүүн бүс	1. Дорнод 2. Сүхбаатар 3. Хэнтий	187600
5. Улаанбаатар	1. Улаанбаатар	217900